

Очирдарь дууны түүх цадиг

Цэндийн Наранчимэг

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль, Улаанбаатар, Монгол Улс

ORCID: <https://orcid.org/0009-0004-2009-4793>

Холбоо барих зохиогч: tstsn91@gmail.com

Хураангуй: Очирдарь ламдаа
Залбирч мөргөмүй
Хол газарт очсон түүнийг минь өршөө
Цаглашгүй наст дээд орших бурхандаа
Зүрхэн мэт түүн дор наснаа шидийг оршвой.

Өнөө үед эх монгол хэлний эрдэнэсийн сан болсон уран тансаг үг хэллэг, өвөрмөц нандин өв сургаалийг бид уламжлалт ардын дуу гүр дууллаас сурч мэдэж болно. Монгол ардын уртын дуу нь монгол ардын дууны сонгодог хэлбэр хийгээд улс үндэстний ардын дуутай харьцуулахад нэн өвөрмөц гайхам үнэхээр монгол уран сэтгэлгээ сод дүрслэл гэж хэлж болно.

Эртнээс эдүгээ хүртэл зуун зууныг дамнан үеэс үед өвлөн дуулж ирсэн уртын дуунд хүний амьдралын утга учир байгаль, нийгмийн үзэгдлийн мөн чанар, дээд тэнгэр, гариг эрхэс, бурхан шашин, уул ус, газар дэлхий, энэрэл хайр, элбэрэл журам гээд мөнхийн сэдвийг тусган илэрхийлсэн байдаг. Ийнхүү утга агуулга аялгууны цар хүрээнээс шалтгаалан айзам, суман, бэсрэг, шашдир, гүр дуу хэмээн ангилан үздэг байна. Монголын радиогийн алтан сан хөмрөг, судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл, эрдэмтэн, хөгжим судлаач, дуучдын аман сурвалжийг бичлэгээр авч баримтжууллаа.

Түлхүүр үгс: эртний дуу, лам нар, үндэсний хэв маяг, аялгуу, үнэн түүх, цэдэг

The History of “Ochirdari” song

Naranchimeg Tsend

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

ORCID: <https://orcid.org/0009-0004-2009-4793>

Corresponding author: tstsn91@gmail.com

Abstract: Ochirdari lamdaa
Zalburch morgomui
Khol gazar ochson tuuniig mini urshuu
Tsaglashgui nast deed orshikh burkhandaa
Zurkhen met tuun dor nasnaa shidiig orshvoi

Today, we can learn the unique and precious heritage of the original Mongolian language from the traditional folk songs. It can be said that the long Mongolian folk song is a classic form of Mongolian folk song and a very unique and wonderful representation of the Mongolian artistic spirit compared to the national folk songs.


From ancient times to the present, long songs have been passed down from generation to generation, reflecting eternal themes such as the meaning of human life, the nature of nature and social phenomena, the sky, the planets, God, religion, mountains, water, earth, love, and order. Thus, depending on the scope of the dialect, it is classified as aizam, suman, besreg, shasdir, and gurdu. The golden treasure of Mongolian radio, articles published by researchers, oral sources of scientists, musicologists and singers were recorded and documented.

Keywords: *ancient songs, monks, national styles, melodies, true stories and records*

Оршил

Монгол Улсын Гавьяат дуучин Жигзавын Дорждагвын бүтээсэн “Очирдарь” хэмээх дуу хальсанд бичигдээд монголын радиогийн алтан санд 40 гаруй жил хадгалагдаж байна. “Эфирт гаргахыг хориглоно” гэсэн бичиг бүхий цаасан хайрцагтай арав гаруй шашины сэдэвт дуутай хальсанд “Очирдарь” дуу багтжээ.

1968 онд Жалан-Аажавыг радио хорооны дарга байх үед шашны холбогдолтой арваад дууг Дорждагва 64 настай байхдаа дуулж, тухайн үеийн кассетад бичиж буулгаад, “Би шашны холбогдолтой арваад дууг дуулчихлаа. Энийг яах вэ? гэхэд радиогийн архивын хүнийг дуудаад энэхүү бичлэгээ нэр хаяг бичилгүйгээр бүр далд хадгалчих гэж хэлсэн” (Юндэнбат, 2022) гэдэг. “Эфирт гаргахыг хориглоно” гэсэн улаан харандаагаар хөндлөн бичсэн бичигтэй маш их бичлэгнүүдээс шүүсэн” (Алтанцэцэг 2023) байдаг. Хавтсан дээрээ “Улсын Гавьяат жүжигчин Дорждагвын дуулсан шажин бурханы сэдэвт ардын урт дуунуудын бичлэг. 1980 оны 6-р сарын 20-нд бичсэн. Зөвхөн алтан фондод авлаа” гэсэн байна. “Эфирт гаргахыг хориглоно”



гэсэн улаан харандаагаар хөндлөн бичсэн бичигтэй уг хальсыг дуу төхөөрөмжид байрлуулж сонсонгуут “Вачирдара” нь Дорждагвын дуулснаар хадгалагджээ.

Бидний эрэл бол 1968 оны бичлэг байсан боловч бидний олоод сонсож

Зураг 1. МҮОНРадиогийн алтан сан, 1980

байгаа бичлэг 12 жилийн дараа буюу 1980 оны 6-р сарын 20-ны тэмдэглэгээтэй бичлэг байсан.

Энэ цаг дор хуурч Пүлжингийн Буян, лимбэч Лувсандоржийн Цэрэндорж нар амьд ахуй байсан учраас хөгжмийг тоглож хамтарсан байна. С.Бүргэд энэ хориглогдсон сан хөмрөгийг олж авч, дахиж сэргээж бичсэн үү, шажин бурханы дуунуудыг тэднийг урьж авчирч дахин дуулуулсан уу гэдгийг одоогоор бидэнд хариулах хүн хэн ч байхгүй. 1980 онд бол Дорждагва 80 нилээд дөхсөн үедээ дуулсан. 1984 онд Мажигсүрэн сонсоод дахиж хөтөлбөр товъёогийг хийгээд наасан. “Очирдарь”, “Ая дангийн гурван ая”, “Гайхамшигт дээд”, “Ялгуусан эрхт”, “Найман арслант”, “Эртийн цагаан буян” ба “Ялгуусан эрхт”-ийг хоёр удаа дуулсан байгаа нь хоёр өөр аялгуугаар дуулсан байж магадгүй байна. 1930-40-өөд оны үед улс төрийн их хэлмэгдүүлэлтийн үе байсан. Монголын төр нийгмийн зүтгэлтэн, хөгжмийн зохиолч, алдарт уртын дууч Дугаржав багш хэлмэгдээд байсан цаг дор монгол ардын дуу болон уртын дууг хэлмэгдүүлэлт тойроогүй дайрсан. Монголын соёлын өвийг тал бүрээр нь устгах гэж үзсэн байдаг. Тэр дуунуудыг дуулахыг хориглосон. Пянзнуудыг эвдэж хагалж хүчингүй болгосон. Эвлүүлэх ямар ч үндэс байхгүй. Тэр үеийн уран бүтээлчид, засаг төрийн удирдагчид ямар сайхан мэргэн ухаантай хүмүүс байж вэ гэж харж байна. Уран бүтээлчид энэ дууны аяыг, үгийг яаж авч үлдэх вэ гэж өдрийн бодол шөнийн зүүд болж байсан. Ингээд аваад үлдсэн нь Дорждагва уртын дууны төлөө л төрсөн хүн. Тэр дууг авч үлдэхийн төлөө зүрх сэтгэл, авьяас чадвар, цаг хугацаа, боломж юу байна бүх зүйлээ зориулсан хүн. “Очирдарь”, “Ая дангийн 3 ая”, “Гайхамшигт дээд”, “Ялгуусан эрхт”, “Найман арслант”, “Эртний цагаан буян” зэрэг шашны сэдэвтэй дуу боловч асар их сургааль, асар их мэдлэг болсон бүтээл. Тухайн нийгэм шашны эсрэг байсан ба шарын шашныг сурталчилж болохгүй гээд шашны дуунуудыг дуулж болохгүй гэж 1960-1980 онд зөвхөн алтан фондод хадгалсан (Буянхишиг 2023).

Судалгааны арга зүй

Монголын радиогийн алтан сан хөмрөг, судлаачдын нийтлүүлсэн өгүүлэл, эрдэмтэн, хөгжим судлаач, дуучдын аман сурвалжийг бичлэгээр авч баримтжууллаа. Дорждагвын гар эх бичмэл, радиогийн алтан сан хөмрөгт хадгалагдаж байгаа бичлэгийг эгшиглээст буулгаж харьцуулсан судалгаа хийв.

Судалгааны үр дүн

Мартагдсан дууг хайж олж сэргээн дэлгэрүүлэх, туулсан зам мөрийн түүхийг үнэн зөв тайлбарлан таниулах, судалгаа сурталчилгааны эргэлтэд түлхүү оруулах нь тухайн дууны эртний ая дан, үг хэллэг, нийгмийн байдал, хүний зан чанар, улс эх орны хөгжил дэвшлийн тухай ирээдүй үе маань таньж мэдэх, мэдлэг олж авах, жинхэнэ эртний аялгуугаар өвлөн дуулж сурах, уртын дууны сан хөмрөгийг арвижуулах, радиогийн сан хөмрөгт хадгалахад чухал нөлөө үзүүлнэ. Мөн дуулах арга техник, заах аргыг судалж аудио бичлэг хийж тэмдэглэж үлдээх, түүнийг дэлгэрүүлэхэд үр нөлөө үзүүлнэ.

“Ямар нэгэн маягаар далд байгаа уран бүтээлүүдийг ард түмэнд хүргэхгүй бол үхмэл хөрөнгө болоод байна. Тэгэхээр алтан фондод байгаа нандин зүйлүүдийг алдар цуутай хүмүүсийн хэлсэн үгийг “Радиогийн хөрөнгө шүү” гэдэг тамга тэмдгийг тавиад нийтэд хүргэж байх хэрэгтэй. Түүний нэг нь шашны дуунууд. Одоо бид юмнаас айхгүйгээр шашны дуунуудыг тайлбартай, болж өгвөл үгтэйгээр нь оруулах хэрэгтэй” (Буянхишиг 2023).

Гүр дууны шүлгийн агуулга дахь орчлон бол зөвхөн хүний амьд орчлон бус, хүний урд хойд нас, ирээдүйд дахин төрөл авах буюу хүний оюун санаа сүнсний байх орчлон гэхчилэн орчлон ертөнцийн үй түмэн юмс үзэгдлийн орон зай, цаг хугацаа, өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн харьцаанд маш өргөн утгаар нь авч үзсэн байдаг хэмээн эрдэмтэн судлаачид дүгнэсэн байна.

Дуу бүхэн өөрийн зохиомжтой байдаг болохоор “Очирдарь” дууг нутаг нутгийн аялгаар нь хадгалах нь зүйтэй. УГЖ Дорждагвын бүтээсэн шашин төрийн холбогдолтой дуу нь монголын радиод болон ардын авьяастнуудын дуулснаар, нутгийн дуучдын дуулснаар хэл зохиолын хүрээлэнгийн алтан санд хадгалагдсан нь хөгжим судлалын, шашин судлалын, утга зохиол судлалын гээд олон талын судалгааны хэрэглэгдэхүүн болон үлдсэн байдаг.

XVII зууны сүүлээс XIX зууны эхэн хүртэл шашин монголд бүх салбарт нэвтэрч байсны нэгэнд яах аргагүй уртын дуу тооцогдох ба шашны сэдэвтэй дуу буюу шашдир гэж тусгай бүлэг дуу гарч ирсэн байдаг. Монгол оронд олон зуун хийд, олон мянган лам хувраг хутагт хувилгаад хүмүүс байсан. Энэ хүмүүс найр хурим, зан үйлд монгол уртын дууг ашиглаж байжээ. Ингэхдээ хоёр зорилгоор шашдир дууг бүтээсэн гэж судлаачид үзэж байгаа ба нэгд нь, жирийн ард иргэд бурхан шашныг өөрсдийнхөөрөө ойлгоод, сэтгэл бодол бүх зүйлээ зориулаад бүтээсэн, нөгөөд нь, хүн ардаа зориулсан гүн ухаан, философийг энгийн байдлаар ойлгуулахын тулд бичгийн мэргэн лам хуврагууд зохиосон гэж үздэг. Энэ хоёр уулзварыг нийлүүлэхээр яах аргагүй уртын дуунд шашны сэдэвтэй шашдир дууг багтааж байгаа ба том сүм хийд нээх, янз бүрийн баяр ёслол, бурхан бүтээх, аравнайлах зэрэг бүх юмандаа дуулдаг, зан үйлийн маш том дуу байсан. Тэгэхээр яах аргагүй монгол ардын уртын дууны бүрэлдэхүүн хэсэг болж байна. Шашдир дуу гэдэг төрөл дотроо гүр дуу, бясалгалын дуу, бурхан шашны дууг хамруулжээ. Эдгээр дуунуудын заримыг нь уртын дууны нэртэй төлөөлөгч Дорждагва зэрэг дуучид үгийг нь өөрчлөөд ч болсон бидний үед хүргэж ирсэн. Тэдний нэг нь “Очирдарь” дуу юм.

Монгол орны нутаг дэвсгэрээр “Очирдарь” дуу бичмэлээр уламжлагдан ирсэн гэж хэлэхэд бэрхшээлтэй. Үг нь одоогийн дуулагдаж байгаагаас их өөр “Очирдарийн залбирал” гэдэг ч юм уу, мөргөл гэдэг юм уу “Очирдарь” гэж тархсан. Одоо бидэнд олдоод байгаа бичлэгийг аман хувилбартай зэрэгцүүлээд үзэхээр хамгийн сонирхолтой нь энэ дуу гүр дууны төрөлд орж байна. Энэ гүр дууг Дорждагва мэддэг байж. Жишээлбэл, гурвын 36 дуу нь номын найрт дуулдаг дуу, 72 гүрийн дуу болохоор хошуу шавийн мөргөлийн дуу, 64 дуу нь бурхан тахилдаа дуулагддаг. Эндээс харахад “Очирдарь” хошуу шавийн холын хүмүүс оролцдог найрт дуулагддаг байсан байх. Гүр дууны энэ бичлэг дээрх үгийг одоогийн үгтэй харьцуулахаар ерөнхийдөө таарч байгаа. Жишээлбэл, 26 (1936) онд хэвлэгдсэн

“Монгол уртын дуунуудын түүвэр”-т Дорждагвын дуулснаар үгийг аяараа сонсож болно.

Очир дарь ламдаа залбиран мөргөө
Холын аянд явсан дүүг минь
Өршөө гэж эхэлж байгаа.
Тэгвэл бичмэл хувилбарт:
Очир дарь ламд залбирч мөргөмүй
Хол газарт очсон түүнийг минь өршөө.
Аман хувилбар дээр:

Холын аянд явсан дүүг минь өршөө гэж байдаг түүний минь, дүү минь гэдэг үгээс бусдаар бараг ижил байна.

Цаглаш үгүй настай дээд бурхан маань

Зүрхэн мэт түүн дор насны шидийг оршвой гэж бичмэл хувилбартаа байгаа. Энэ хоёр мөр нь “Холын аянд явсан дүүг минь уулзуулж өршөө” гэдэг байдлаар гурван мөртэй, дунд нь “Дээд баатар манзуширын богд очирваань эрхэм ах” гээд тус бүрдээ таван бадаг болж, бурхдыг дэс дараалан дурдаж, мөргөн залбирч байгаа нь бичмэл эх хувилбар дээрээ байна. Аман хувилбар дээрээ энэ болгон хураагдсан. Иймээс “Очирдарь” дууг гүр дуу гэж үзэж болно (Алимаа 2023).

Монголчуудын урлаг соёлын түүхэнд хүний оюун ухааныг хөгжүүлэх чиглэлээр туурвигдан гарч ирсэн бүтээл бол бодол бясалгалын дуулал гүр дуу байдаг. Гүр дуу нь XVII-XVIII зууны үеийн монголчуудын оюун сэтгэлгээний түүхэнд гарч ирсэн том туурвилуудын нэг бөгөөд буддын шашны урлахуйн ухааны үндэс суурин дээр тулгуурлан, хүний оюун ухаан, бодол бясалгалын ухааныг хөгжүүлэх чиглэлээр зохиогджээ. Хуучны Сайн ноён хан аймаг, одоогийн Баянхонгор аймгийн Галуут сумын чин сүжигт Номун ханы хийдээр дэлгэрч байсан гүр дууны бичиг бол монгол хэл бичиг, аман зохиол, утга зохиолын төдийгүй зан үйл, угсаатны зүй, түүх, соёл урлаг, монголчуудын оюун ухаан, уран сайхны сэтгэлгээнд гарч ирсэн нэгэн томоохон амжилт, бодитой дурсгалт соёлын биет болон биет бус өвийн нэг юм. Гүр дуу нь буддын шашны сүм хийдийн номын найрын зан үйлд дуулах намуун, дөлгөөн, удаан, тайван өнгө аястай уртын магтаал дууны төрөл юм. Гүр дууллын аяс, шүлэг, яруу найраг бол жирийн иргэн ардын дууны өгүүлэмжээс ялгаатай, бурхдыг магтан дуулсан өгүүлэмжтэй байдаг. Үүний үр дүнд хүний оюун сэтгэлгээний гүнээс гарсан эрчим хүчний урлалаар дамжин дуулдаг бясалгалын дуу юм. Гүр дуунд нийт гурван зүйлийн хөг аяс тэмдэглэгдсэн байдаг. Дээд хөг, доод хөг, сахар хөг гэсэн гурван хөгөөр дуу бүрийг ялган зааглаж, тодорхой бүлэг болгон ангилсан байдаг. Энд нийт 40 бүлэг бөгөөд 81 эхт дууг тэмдэглэсэн гар бичмэл арваад олдсон байна. Гүр дууны шүлгийг танин мэдсэн учраас дуу бүрийг тодорхой хөгт хамаатуулан авч үзсэн байна. Энэ нь нэгэн авианы гадаад дотоод тал бус авианы мах бодийн мөн чанараас нийлэмжтэй буюу нийлэмжгүй авиа эгшиглэгээг өөрөөр хэлбэл, аялсан шадыг танин мэдэх учраас энэ хөгийг тогтоосон гэж үздэг. “Вачирдара” дууг зохиол дотор хоёр янзаар тэмдэглэсэн. 61, 62 дугаар дуу, 29 дүгээр бүлэг гэж ангилсан. 61, 62 дугаар дуу бол “Шавар байшин”, “Вачирдара” гэж дуу байна. Энэ хоёр дуу нэг хөг нь нэг аятай дуулагдана гэж тэмдэглэгдсэн байна.

Лувсанванчинбалбар нь Халхын чин сүжигт номун хан Норовшарав (1701-1768) лугаа балчир багаас Өндөр богдын дэргэд хамт өсч хүмүүмжсэн бөгөөд Чингис тэнгэрийн удмын улбаа, үе зэргийн хоёр тойн шашны сургаал номын сэдэвтэй, гүн сэтгэлгээ, уянга бясалгалын аястай шүлэг дуулал бүтээлцэж явсан бөгөөд тэрбээр бурхад дошгидыг магтах, номын багш ихэс лам нартай уулзаж ёслох, номын хурим үйлдэх, хийд хүрээ байгуулж, найр наадам үүсгэх зэрэг онцлог содон үйл явдалд зориулан “Галбингын эгшиг” (1742), “Диваажингийн орон” (1743), “Төрийн товч” (1728), “Дэлгэр их шашин” (1759) зэрэг шашин номын сэдэвтэй гүр дууллыг (Баянхонгор музейн сан хөмрөг) ардын уртын дууны баялаг уламжлалд тулгуурлан туурвиж, монголын бурхан шашины уран зохиолд хувь хандиваа оруулсан юм. Ламын гэгээний гуравдугаар дүр Лувсанцэвээнжав (1789-1846) өөрт нь гэлэн сахил хүртээсэн номын багш номун хан Лувсандандарванчугт хандаж “Төрийн товч” дууг айлдсан болов уу. Ламын гэгээний дараа дараачийн дүрүүд дуу зохиож ирсэн уламжлалыг үргэлжүүлж, “Гайхамшигт” хэмээх айзам уртын дууг нутгийн дуучидтай хамтран зохиосон (Үнэн 1993) гэдэг. Иймээс ламын гэгээний хийдэд “Гайхамшигт”, “Төрийн товч”, “Дэлгэр их шашин”, “Галбингийн эгшиг” зэрэг дууг дуулдаг байжээ (Юндэнбат 2018, 121).

Номун хан 27 сүүдэр дээрээ ширээт ламын гэгээнтнээс олон зүйлийг соёрхол айлдаад, ламдаа маш их сүжиг төрж, бас удирдан мөргөхийн “Очирдарь” хэмээх шүлэглэж тэмдэглэсэн байна. Зарим газар “Очирт дарь”, зарим газраа “Мөргөхийн Вачирдара” гэж байгаа. “Вачирдара” дуу бол нийтдээ 60 мөрт шүлгээс бүрддэг. Эртний дуулагдаж байсан шүлгийг танилцуулъя.

Зээ Вачирдара лам минь орой дээр сууж

Бодь түргэн олохыг адислан соёрх

Зовлонт орчлонд учирснаа санаж

Сэтгэлд уйтгар төрүүлж ламдаа залбирмуй

Яндар тэргүүтэн ядам бурхан бүгд дээд ба ерийн шидийг өршөөн соёрхоо

Нисваанисийн хилэнцээр эндүүрсэн манийг нигүүлсэн адислаж

Жаргал нь зохио

Шагжам ном тэргүүтэй туулсан бурхадууд арилсан орондоо удирдан соёрхоо

Баримтлан эзэлсэн мунхарсан намайг билиг билгийн гэрлээр гийгүүлэн өчмүй

Мандзашир тэргүүтэн их бодь садваа нар хагацал үгүй дагана удирдан соёрхоо


Тэнцэлгүй амгалан долоон шөнө төгссөн Вачирдарийн чанарыг түргэн олохыг бүтээ

Үүссэн бүгдийг мөнх бус санаад алс мөрийг санаж л ийн дуугаа дуулав

Шажин хийгээд амьтны тус сайтар бүгдийг бодь мөр удирдах болтугай

гэсэн 60 мөр шүлэг байна. Гүр дууны дотор бичихдээ, 29 дүгээр дуу “Шавар байшин”, “Вачирдара” энэ хоёрын ая ижил бөгөөд дээд хөгт дуулна гэж тэмдэглэгдсэн (Эрдэнэчимэг 2023). Иймээс Вачирдара дууг Ламын гэгээний хийдэд дуулагдаж байсныг Эрдэнэчимэг судлаач тэмдэглэсэн байна.

Хувьсгалын дараах үед энэ Вачирдара дууны үг өөрчлөгдөж зохиогдон, “Нам төр”-өө магтан дуулсан дуу болсон. Үгийг нь О.Намнандорж аялгууны ноот бичгийг алдарт уртын дууч Дорждагва тэмдэглэн үлдээсэн гар бичмэл хадгалагдаж байна.



Зураг 2. Дорждагвын хувийн сан хөмрөг, 1971


Их дуучин Дорждагвын 1971 оны гар бичмэлд аялгууг таван шугамт ноотоор тэмдэглэж, нийтээр дуулагдахыг зөвшөөрөв /Лувсаншарав гэсэн гарын үсэгтэй үлдсэн байна (Дорждагва 1971).

УГЖ Дорждагвын зохиосон аялгууг нэрт соён гэгээрүүлэгч, түүхч Намнандоржийн “Нам төр” шүлэгтэй зохируулсныг 2024 онд радиогийн нэвтрүүлэгт МУГЖ Б.Мөнхбаатар дуулж, морин хуурч Х.Ганбилэг хөгжимдсөн.

Уртын дуу нь уудам тэнэгэр аялгуу, уянга төгөлдөр гоёмсог чимэг нугалаа цохилготой өргөн цараатай сонсоод ханамгүй эгшиглэнтэй билээ.

“Очирдарь” дууны аялгууны онцлог нь “Очирдара” хэмээх шашдир, нөгөө талаасаа гүр дуунд ч тооцогдох энэ дуу нь эх хэлбэрийн хувьд урт аялгуутай богино аялгуутай гэсэн хоёр хэлбэрээр уламжлагдсан байдаг. Богино аялгуу нь өвөр монголын Ордос орчимд уламжлагдан хадгалагдсан байна.

Уртын дууны урт аялгуутай хувилбар бол Монгол Улсын нутаг дэвсгэрт, тэр дотроо халх монголчуудад голдуу хадгалагдсан байдаг. Энэ нь Баян бараат аялгуугаар байдаг. Мөн хангайн халх буюу Баянхонгорын аялгуугаар, төв халх аялгуугаар буюу Цэцэнханы аялгуугаар дуулагдаж байгаад нилээд тасарч бүдгэрсэн шинжтэй (Дорждагва 2024). Тэр аялгууг нь Дорждагва нэг бадаг эхлүүлээд дуулж үлдээсэн байна (Дорждагва 1980).



Зураг 3. Дорждагвын “Нам төр” дууны эгшиглээст бичсэн гар бичмэл, 1971

Ачлалт намынхаа үйлсэд зориглонхон явж зүтгээрэй

Аштын /ла/ эрхэм зорилго аймшиггүй /ла/ явж бүтээгээрэй

Энэрэнгүй гэгээн төрдөө /нь/ итгэлтэй /ло/ шударгаар ажиллаарай

Эрэлхэг Монгол Улсаа эрчимтэй /ла/ явж мандуулцаая

Баатарлаг эх орныгоо бадрангуй зоригоороо хөгжүүлцгээ

Баялаг бүхнийхээ сан хөмрөгийг нөөцлөн явж ашиглацгаая

Тансаг сайхан орондоо тайван амгалан жаргацгаая

Таван тивийн ажилчидтайгаа дотноор явж найрамдацгаая гэж бичжээ.

Хэлэлцүүлэг

Уртын дуу дуулах үйл ажиллагаа бол үндсэндээ танин мэдэхүйн үйл ажиллагаа байдаг. Судалгаагаар сэрэл хүртэхүй, анхаарал ой тогтоолт, зохион бодохуй сэтгэхүй, хэлэхүй буюу дууг илэрхийлж байгаа үйл явцаар дуулах үйл ажиллагааг нэг талаас тодорхойлж болно. Нөгөө талаасаа уртын дуу дуулах үйл ажиллагаа бол өөрөө биологийн үйл явц. Тиймээс уртын дуучдын өөрсдийн дотоод өөрчлөлт нь биологийн өөрчлөлт байдаг. Тэгэхээр “Очирдарь” дуу шашны бясалгалын шинжтэй учраас дээр дурдсан танин мэдэхүйн үе шатуудаар бүтсэн. Онолын хувьд богино аялгуугаар дуулахад ч урт аялгуугаар дуулахад ч мөн адил танин мэдэхүйн 7 үе шатыг дамжин илэрч байх ёстой. Тийм учраас дуулсан дуучид өөр өөрийнхөө үеийн онцлогоо, уртын дууныхаа талаарх өөрсдийн мэдлэг, уртын дуу дуулдаг өөрсдийн чадвар, уртын дуунд ханддаг өөрсдийн хандлага нь “Очирдарь” дууг хэрхэн яаж илэрхийлэхээс харах боломжтой юм.

“Очирдарь” дууны нийтлэг онцлогийг ч, дуулсан дуучдын угсаатны нутаг нутгийн онцлогийг ч танин мэдэж болно. Хамгийн чухал нь тухайн дууны үг шүлгийн хувилбаруудыг маш сайн харж, уртын дууг яруу найргийн бүрэн эхээр нь дуулж сурах баганаан функцийн аргачлалыг ашиглаад, ямар үгэн дээр нь ямар аялгуу байна гэдгийг эхний бадаг тодорхойлдог. 20, 30 минут дуулах дадлыг эзэмшээгүй учраас дуучид бүтнээр нь дуулж чаддаггүй. Тийм учраас “Очирдарь” дууг дуулсан энэ хувилбарууд үнэхээрийн үнэ цэнтэй. Цаашид аль нэг хувилбараар нь бүрэн бүтнээр дуулах, сонсогчдод бүрэн бүтнээр сонсох, хүртээхэд, ХХI зууны уртын дуучдын уран бүтээлийн чиг хандлагад нийцэх ийм бүтээл туурвия гэвэл эхний нэг бадгийг танилцуулах сурталчилгааны хандлагатай хувилбарууд маш чухал юм. Энэ дууны аялгуунууд, илэрхийлж байгаа илэрхийлэлүүд бол онцгой чухал гэдгийг хэлэх нь зүйтэй.

Гавьяат дуучин Жигзавын Дорждагва, Ардын жүжигчин Дамдинжавын Түвшинжаргал, Улсын Гавьяат жүжигчин Бат-Өлзийн Мөнхбаатар, уртын дуучин, судлаач Мягмарсүрэнгийн Дорждагва нар өөр өөрийн гэсэн хэв маяг, донж, барилт, нугачаа, цохилгыг хийж дуулснаараа ялгаатай боловч дууны үндсэн ая өөрчлөгдөөгүй. Дуучин Д.Түвшинжаргалд Дорждагва яг үндсэн аялгуугаар нь зааж сургасан ч 1988-1989 оноос хойш дуулаагүй, дуучин Б.Мөнхбаатар “Нам төр” дууны гар бичмэлийн ноотыг харж дуулсан бол, М.Дорждагва их дуучны дуулсныг сонсож байж дуулсан байна. Их дуучнаас бусад нь ямар нэгэн архивд хадгалуулаагүй байна.

Дүгнэлт

Шашны эсрэг байсан цаг үед шарын шашныг сурталчилж болохгүй, шашны дуунуудыг дуулж болохгүй гэж хориглосон. Түүний нэг “Очирдарь” дууг зөвхөн 1960-1980 онд алтан фондод хадгалсан. Монголын радиогийн фондод байгаа бүтээлүүд үнэхээр гайхамшигтай. Түүнийг эрж хайж, олж, гаргаж олны хүртээл болгох хэрэгтэй, гэхдээ зарж мөнгө болгож болохгүй. Ямар нэгэн маягаар далд хадгалагдан байгаа бүтээлүүдийг ард түмэнд хүргэхгүй бол үхмэл хөрөнгө болоод байна. Тиймээс алтан фондод байгаа нандин зүйлүүдийг алдар цуутай хүмүүсийн

хэлсэн үг, дуу хуурыг радиогийн хөрөнгө шүү гэдэг тамга тэмдгийг тавиад нийтэд хүргэж байх хэрэгтэй. Одоо бид юмнаас айхгүйгээр шашны дуунуудыг тайлбартай, болж өгвөл үгтэйгээр нь оруулах хэрэгтэй. “Очирдарь” дууг олны хүртээл болгож, эртний аялгуу, үгээр нь дуулж, радиогийн алтан сан хөмрөгт хадгалж үлдэх нь чухал байна. Мөн эртний мартагдаж дуулагдахгүй байгаа дуунуудыг сан хөмрөг болон судлаач эрдэмтдийн сан хөмрөгөөс эрж хайж түүх, дуулах арга барил, дэг соёл, хоолойн цараа зэргийг задлан шинжилж судлах шаардлагатай байна. Тиймээс “Очирдарь” дууг олны хүртээл болгож сэргээж байгаа нь үнэ цэнтэй.

Ашигласан материалын жагсаалт

Монгол Улсын гэгээрлийн яам. 25 (1935). *Монгол урт дуунуудын түүвэр*, Улаанбаатар хот: Улсын хэвлэлийн газар.

Эрдэнийн очир ТББ. 2020. *Монгол дуунууд аялгуу нотын хамт*. Ред. Түвшинтөгс Б., Улаанбаатар хот: Мөнхийн үсэг.

Туяацэцэг, Цэрэн. 2021. *Хуур магнайн эгшиг монгол уртын дуунууд*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс.

Юндэнбат, Соном-иш. 2018. “Ламын гэгээний ханчин дэгийн ёслол, зан үйлийн судалгаа.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Ярилцлага:

Дамдинжавын Түвшинжаргалтай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Монгол улсын консерватор, 2022.

Гэрэлцогтын Ганцэцэгтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: МҮОНРТ, 2024.

Лувсанноровын Эрдэнэчимэгтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Цэнгэлдэх хотхон, 2023.

Чойжамцын Буянхишигтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: МҮОНРТ-ийн урлаг соёлын редакц, 2023.

Бат-Өлзийн Мөнхбаатартай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Морин хуурын чуулга, 2023.

Мягмарсүрэнгийн Дорждагватай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Хөдөлмөрийн дээд сургууль, 2024.

Соном-Ишийн Юндэнбаттай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: СУИС, 223 тоот, 2023.

Бат-Очирын Алтанцэцэгтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: МҮОНРТ-ийн дуу техникийн өрөө, 2023.

Пүрэвдоржийн Эрдэнэцэцэгтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: МҮОНРТ-ийн фондны өрөө, 2023.

н.Энхтайвантай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: 79 дүгээр сургууль, 2024.

Архив дахь бичлэг:

ШУА-ийн хэл зохиолын хүрээлэнгийн архив. *Очирдара дууны аман сурвалжийн бичлэг*. хн.160-B-1, 341-A-11, 367-B-21, 593-B-48,56.

Соёлын өвийн үндэсний төвийн дуу дүрс бичлэгийн студийн сан хөмрөг. *Очирдарь. Аман сурвалжийн бичлэг*. 423. Кассет, DV89.

Соёлын өвийн үндэсний төвийн дуу дүрс бичлэгийн студийн сан хөмрөг. *Дундговь аймгийн Мандалговь сумын ардын урлагийн их наадам. Аман сурвалжийн бичлэг*. 297. Кассет. DV363.

Хувийн цуглуулга:

Жигзавын Дорждагвын гар бичмэл “Нам төр”. 1971. Хувийн хөмрөг.

CD:

Мөнх тэнгэрийн аялгуу уртын дууны цомог 2. 2004.